АЖЛЫН БАЙР (АЛБАН ТУШААЛ)-НЫ ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

☑ Байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоонд өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомж, шийдвэрийн нэр, огноо: "ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны А/49 дүгээр тушаал

Албан тушаалын тодорхойлолтын дугаар: "ИНҮТ" ТӨХХК - 57

Албан тушаалын тодорхойлолтыг батлсан огноо, дугаар: 2025.03.14 А/124

Байгууллагын нэр: "Иргэний нисэхийн үндэсний төв" ТӨХХК

Нэгжийн нэр: Аюулгүй байдал, чанарын удирдлагын газар

Албан тушаалын нэр: Нислэгийн журмын үйлчилгээний хяналтын технологич мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ажлын цаг: Ердийн

Ажлын байрны албан ёсны байршил: ХУД-ийн 21-р хороо, "ИНҮТ" ТӨХХК

Хөдөлмөрийн нөхцөл: Хэвийн

Онцгой нөхцөл:

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

ИНД 173 дүрмийн шаардлагын хүрээнд явуулж буй нислэгийн журмын үйлчилгээнд аюулгүй байдал, чанарын хяналтыг тогтмол тавьж, хяналт шалгалт хийх, аюулгүй байдлын эрсдэлийн судалгаа, шинжилгээ, үнэлгээ хийх, эрсдэлийг бууруулах ажлыг телевлех, аюулгүй байдал, чанарын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулах, аюулгүй байдал, чанарын мэдээ, мэдээлэл, гүйцэтгэлийн хэмжүүрүүдийг тогтоох, нэгтгэх, бүртгэх, дүн шинжилгээ хийх.

Албан тушаалын зорилт:

1. Нислэгийн журмын үйлчилгээний аюулгүй байдал, чанарын хяналтыг тогтмол хийх, хугацаат болон хугацаат бус аюулгүй байдал, чанарын хяналт шалгалтын ажлыг хийх;
2. Хариуцсан чиглэлээр аюулгүй байдал, чанарын хяналтын баримт бичгийг боловсруулах, хянах;
3. Аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, судалгаа хийх, эрсдэлийг бууруулах ажлыг төлевлөх, аюулгүй байдал, чанарын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулах;
4. Аюулгүй байдал, чанарын мэдээ, мэдээлэл, гүйцэтгэлийн хэмжүүрүүдийг нэгтгэх, бүртгэх, аюулгүй байдлын гүйцэтгэлийн үзүүлэлтүүд болон чанарын гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг сайжруулах судалгаа, дүн шинжилгээ хийх;
5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх-Ш

1 дүгээр зорилтын хүрээнд	1.1.Нислэгийн журмын үйлчилгээ, түүний систем тоног төхөөрөмжийн бэлэн байдалд аюулгүй байдал, чанарын хяналтыг тогтмол тавих, аюулгүй байдлын өгөгдөл мэдээллийг бүртгэх; 1.2.Нислэгийн журмын үйлчилгээний үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг үнэлэх, сайжруулах санал, дүгнэлт, зөвлөмж гаргах; 1.3. Нислэгийн журмын үйлчилгээний үйлдвэрлэлийн бэлэн байдалд аюулгүй байдал, чанарын хугацаат болон хугацаат бус хяналт шалгалтыг хийх, тайлан боловсруулах; 1.4. Хяналт шалгалтаар илэрсэн дутагдлыг залруулахад чиглэсэн бодит баталгаа бүхий дүгнэлт, зөвлөмжийг боловсруулах, хэрэгжилтийг хянах, үнэлэх; 1.5. Бүтээгдэхүүн, үйлчилгээ, байгууламжийн доголдлын зөрчил, ноцтой гэмтлийн бодит шалтгааныг тодорхойлох, дүн шинжилгээ хийх, арилгах дүгнэлт, зөвлөмжийг боловсруулах; 1.6. Ажилтан болон хамтран ажилладаг байгууллага, хэрэглэгчээс ирүүлсэн аюулгүй байдал, чанарын тогтолцоотой холбогдолтой шаардлага, хүсэлт, гомдолд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг зохион байгуулах; 1.7. Хөндлөнгийн хяналтын байгууллагын үзлэг шалгалт болон гэрчилгээ олгогч байгууллагын илрүүлсэн үзлэг шалгалтын дүгнэлт, зөвлөмж, шаардлагын дагуу запруулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжилтэд хяналт тавих; 1.8. Компанийн болон газрын үйл ажиллагааны төлөвлөгөөг хангах, хувийн төлөвлөлтийг хийх, биелүүлэх, хэрэгжилтийг тайлагнах,	Нислэгийн журмын үйлчилгээний аюулгүй байдал, чанарын хяналт тогтмол хийгдэж, хугацаат болон хугацаат бус аюулгүй байдал, чанарын хяналт шалгалтын ажлыг хийсэн байна.	Г, Х Г, Х Г, Х Г Г Г, Х Г Г
2 дугаар зорилтын хүрээнд	2.1. ИНД-ийн хүрээнд үйл ажиллагааны ерөнхий зааварт аюулгүй байдал, чанарын удирдлагын тогтолцооны баримт бичгийг боловсруулах, хянах; 2.2. Аюулгүй байдал, чанарын удирдлагын тогтолцооны баримт бичгийг боловсруулах, хянах; 2.3. Хариуцсан чиглэлээрх зохицуулалтын журам, зааврыг хянах, шаардлагатай үед дүн шинжилгээ, хийж, өөрчлөлт шинэчлэлт оруулах санал боловсруулах; 2.4. Компанийн дотоод үйл ажиллагаанд мөрдөн ажиллах баримт бичгүүдэд санал тусгах, хянах, шаардлагатай тохиолдолд боловсруулах; 2.5. Аюулгүй байдал, чанарын удирдлагын хяналт шалгалтын ажлын хуваарь, удирдамжийн төслийг боловсруулах; 2.6. Шаардлагатай үед Нислэгийн журам зохиох, шалгах, баталгаажуулах үе шатуудад биечлэн оролцож, холбогдох зохиолт, баталгаажуулалтыг гүйцэтгэх;	Аюулгүй байдал, чанарын хяналтын баримт бичиг боловсруулагд-сан байна.	Г, Х Г, Х Х Г, Х Г Г, Х
3 дугаар зорилтын хүрээнд	3.1. Нислэгийн журмын үйлчилгээ, түүний тоног төхөөрөмжийн үйл ажиллагааны болзошгүй аюул эрсдлийг тогтоох, аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг боловсруулах, эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөх;	Аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийгдэж, эрсдэлийг	Г Г

	3.2. Нислэгийн журмын үйлчилгээтэй холбоотой нэгдмэл үйл явцын аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хамтран боловсруулах; 3.3. Үйлчилгээний горимын өөрчлөлт, шинэчлэлттэй холбоотой үйл явцуудад аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хийх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг тодорхойлох, боломж, өөрчлөлтийн үнэлгээ хийх, хэрэгжүүлэх арга хэмжээг авах санал боловсруулж удирдлагад танилцуулах, гүйцэтгэлд хяналт тавих, зөвлөмж гаргах; 3.4. Эрсдэл, боломж, өөрчлөлттэй холбоотой бүртгэл хөтлөх, хадгалах.	бууруулах ажлыг төлөвлөн, аюулгүй байдал, чанарын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан байна.	Г, Х Г
4 дүгээр зорилтын хүрээнд	4.1. Аюулгүй байдал, чанарын гүйцэтгэлийн үзүүлэлтийг тодорхойлох, хянах, үнэлэх, холбогдох өгөгдлийг цуглуулах (KPI, SPI); 4.2. Нислэгийн журмын үйлчилгээний аюулгүй байдлын гүйцэтгэлийн үзүүлэлтийг сайжруулах чиглэлээр судалгааны ажил хийх; 4.3. Судалгаанд суурилсан үйл ажиллагааг төлөвлөн санал боловсруулах, зөвлөмж гаргах; 4.4. Газрын мэргэжилтнүүдтэй хамтран багаар ажиллаж, аюулгүй байдал, чанарын удирдлагын тогтолцоог сайжруулах санал гаргах.	Аюулгүй байдал, чанарын гүйцэтгэлийн хэмжүүр, гүйцэтгэлийн үзүүлэлтүүд болон чанарын гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг сайжруулах судалгаа хийгдсэн байна.	Г, Х Г Г Г
5 дугаар зорилтын хүрээнд	5.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт, дүрэм, технологийн горимыг чанд мөрдөх; 5.2 Ажил олгогчийн зүгээс хууль тогтоомжийн хүрээнд нийцүүлэн тавьсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг биелүүлж ажиллах; 5.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан байх, аюулгүй ажиллагааны зааварчилга авсан байх; 5.4 Ажил, үүргээ осол эндэгдэлгүй гүйцэтгэх арга барил, мэргэжлийн ур чадвар эзэмших, осол гэмтэл, хурц хордлогоос сэргийлэх, болзошгүй аюул, ослын үед анхны тусламж үзүүлэх чадвар эзэмшсэн байх; 5.5 Осолд дөхсөн тохиолдлыг бүртгэх болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, үйлдвэрлэлийн орчинд учирч болох аюулыг илрүүлэх, тогтоох, үнэлэх, бууруулах, арилгах талаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтанд мэдээлэх, хамтран ажиллах;	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хангагдсан байна.	Г Г Г Г Г, Т
Ажлын байрны зорилгын хүрээнд явуулах бусад үйл ажиллагаа	• Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хэрэгжүүлж ажиллах, гүйцэтгэлийг эргэн тайлагнах; • Удирдлагын цохолтоор ирсэн албан бичгүүдийг хууль, журмын дагуу Монгол хэлний утга зүй, найруулга, дүрмийн алдаагүй, үнэн зөв боловсруулах; • Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах, гүйцэтгэлийн тайланг гаргаж, тогтоосон хугацаанд үнэлүүлэх; • Хөдөлмөрийн дотоод журамд тусгагдсан байгууллагын соёл, эрхэмлэх үнэт зүйлс,	Удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгавар, ажлын байрны хүрээнд явагдсан бусад үйл ажиллагаа бүрэн хангагдсан байна.	Г Г Г Г

	ажилтны манлайлал, ёс зүйн хэм хэмжээг мөрдлөг болгон ажиллах; • Мэдлэг ур чадвараа дээшлүүлэх талаар идэвх чармайлт, санал, санаачилга гарган ажиллах; • Компанийн "Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт"-ын дагуу баримт, материалыг архивын нэгж бүрдүүлэн бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөх;		Г Г

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА		
Боловсрол	Дээд боловсролтой, бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй	
Мэргэжил	Нисгэгч, штурман, нислэгийн удирдагч Нислэгийн журам зохиогч	
Мэргэшил	• Дотоод аудиторын гэрчилгээтэй байх; • Аюулгүй байдлын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээжсэн байх. • Чанарын удирдлагын тогтолцооны сургалтад хамрагдаж гэрчилгээжсэн байх	
Туршлага	Иргэний нисэхийн салбарт 5-аас доошгүй жил, нислэгийн журмын үйлчилгээний чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан байх.	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	• Мэдээллийн дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; • Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; • Судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй байх. • Шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх.
	Асуудал шийдвэрлэх	• Хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэрийг шуурхай гаргах; • Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; • Албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд аливаа асуудлыг хууль болон ёс зүйг сахиж, ашиг сонирхлоос аливаа зөрчлөөс сэргийлж, авлига, хүнд суртлаас ангид ажиллах; • Тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, хувилбарыг боловсруулж, түүний эерэг, сөрөг үр дагаврын талаар удирдлагад танилцуулах.
	Багаар ажиллах	• Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; • Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; • Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах; • Өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх;
	Бусад	• Албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах; • Компьютерийн өргөн хэрэглээний программ хангамж, тоног төхөөрөмжийг ашиглах чадвартай; • Монгол хэл, бичгийн дүрмийн дагуу үг үсгийн болон утга найруулгын алдаагүй бичих; • Монгол бичгийн анхан шатны мэдлэгтэй байх; • Албан тушаалын чиг үүрэгт хамаарах асуудлаар англи хэл, бусад гадаад хэлээр мэдээллийн эх сурвалж ашиглах; • Ачаалал даах чадвартай байх; • Хувийн зохион байгуулалт, цаг ашиглалтын менежмент сайтай байх;

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ	
Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: АБЧУГ-ын дарга, үйлдвэрлэл хариуцсан менежер, нислэгийн журам, нисэхийн мэдээллийн үйлчилгээний аюулгүй байдлын ахлах технологич мэргэжилтэн	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект: - Иргэний нисэхийн ерөнхий газар - Компанийн харьяа салбар нэгжүүд - Иргэний нисэхийн салбарын бусад байгууллагууд - Хамтран ажиллах гэрээ бүхий гадаад, дотоод байгууллагууд

	- Ажил хэргийн хүрээнд харилцах бусад байгууллага, иргэд

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: ЗАХИРГАА, САНХҮҮ ХАРИУЦСАН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР .....Н.ЗОЛЖАРГАЛ 2025 оны 03 дугаар сарын 14-ны өдөр	Байгууллагын нэр: "ИНҮТ" ТӨХХК Шийдвэрийн огноо: 2025.02.18 Дугаар: А/49

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: "ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨХХК

Шийдвэрийн огноо: 2025 оны 03 дугаар сарын 14 өдөр

Дугаар: А/1241

(тамга/тэмдэг)

УЛААНБААТАР ХОТ

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ТӨХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ОТГОНСҮХ

2025 оны 03 дугаар сарын 14-ны өдөр